



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2026 оны 05 сарын 12 өдөр

Дугаар А/350

Булган сум



Гэрээ байгуулах эрх олгох тухай



Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.21 дэх заалт, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.2.1 дэх заалт, Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн хуралдааны XII/90 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Байгаль хамгаалах сангийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих “Уул уурхайн олборлолт болон авто замын бүтээн байгуулалтын улмаас эвдэрсэн газрыг нөхөн сэргээх зардал (Бугат сум 2-р баг 18-тын дөрөлж 9.47 га)” төсөл арга хэмжээг гүйцэтгэх гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хорооны 2026 оны 04 дүгээр сарын 30-ны өдрийн хурлын зөвлөмжийн дагуу гүйцэтгэгчээр шалгарсан “ЭДМООР” ХХК-тай 65,000,000 (жаран таван сая) төгрөгөөр гэрээ байгуулах эрхийг Байгаль орчны газар (А.Гантөмөр)-т олгосугай.

2. Гүйцэтгэж буй ажилд чанарын болон хугацааны хяналт тогтмол тавьж, хүлээн авахыг Байгаль орчны газар (А.Гантөмөр)-т үүрэг болгосугай.


3. Гэрээнд заасан ажлыг холбогдох хууль, журам, стандарт, зураг, төсвийн дагуу гүйцэтгэж хүлээлгэн өгөхийг “ЭДМООР” ХХК-ийн захирал (Р.Энхбаяр)-д даалгасугай.

4. Гэрээнд тусгах нөхцөл шаардлагыг 1 дүгээр хавсралтаар, тухайн төсөл арга хэмжээг гүйцэтгэхээр санал болгосон инженер, техникийн ажилчид, машин механизмын жагсаалтыг 2 дугаар хавсралтаар тус тус баталж, заагдсан үзүүлэлтүүдийг гэрээнд тусган хяналт тавин ажиллахыг хариуцсан албан тушаалтнуудад даалгасугай.

5. Тус ажлын санхүүжилтийг холбогдох хууль тогтоомж, гэрээний дагуу Байгаль хамгаалах сангийн хөрөнгө оруулалтаас санхүүжүүлэхийг тус сангийн нягтлан бодогч (Б.Очирсүрэн)-д зөвшөөрсүгэй.


ЗАСАГ ДАРГА

Д.ЛҮРЭВ-ОЧИР



6326010478

А/300
Аймгийн Засаг даргын 2026 оны
05 дугаар сарын 12 -ны/ний өдрийн
... дугаар захирамжийн 1 дүгээр хавсралт



Гэрээнд тусгах нөхцөл шаардлага

д/д	Нөхцөл шаардлага	Мөнгөн дүн	Хариуцах албан тушаалтан
1	2	3	4
1	Алданги	Хоног тутамд гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгийн 0.3 хувь байна. Нийт алдангийн хувь гүйцэтгээгүй үүргийн 10 хувиас хэтрэхгүй байна.	Б.Ариунболд (Санхүү, төрийн сангийн хэлтэс)
2	Чанарын баталгаа	Гэрээний үнийн дүнгийн 5-10 хувь байхаар гэрээнд тусгана.	Б.Ариунболд (Санхүү, төрийн сангийн хэлтэс) А.Гантөмөр (Байгаль орчны газар)
3	Ажил гүйцэтгэх хугацаа	Хуанлийн 50 хоног	А.Гантөмөр (Байгаль орчны газар)

--o00o--

Аймгийн Засаг даргын 2026 оны
09 дугаар сарын 12-ныний өдрийн
А/360 дугаар захирамжийн 2 дугаар хавсралт

Тухайн төсөл арга хэмжээг гүйцэтгэхээр санал болгосон инженер, техникийн
ажилчид, машин механизмын жагсаалт

Инженер, техникийн ажилчид			Хариуцах албан тушаалтан
№	Албан тушаал	Ажилтны нэр	
1	2	3	4
1	Газар зохион байгуулалт	Ю.Өнөрбилгүүн	А.Гантөмөр (Байгаль орчны газар)
2	Байгаль орчны хяналт үнэлгээ	Э.Хонгорзул	
Машин механизмын жагсаалт			А.Гантөмөр (Байгаль орчны газар)
№	Машин механизмын нэр	Улсын дугаар	
1	Ачааны автомашин	1617 ТТА	
2	Бульдозер	1571 УР	
3	Ковш	2529 ММА	

--о00о--